



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/46

Булган сум

Гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалт, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн II дугаар хавсралтын хуулийн дугаар XII.1.111 дэх хэсэг, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 108-р тушаалаар батлагдсан “Зураг төслийн жишиг үнийн дүрэм” БД81-16-20 тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн Хишиг-Өндөр, Сайхан, Гурванбулаг, Бүрэгхангай, Баяннуур суманд Монгол Улсын 2021 оны төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан нэг маягийн хүүхдийн тоглоомын талбайн ажлын зураг төсвийг Булган, Дашинчилэн, Хангал, Хутаг-Өндөр, Бугат, Баян-Агт сумдад холболтын ажлын зураг төсвийн үнэ болох 18,720,000 (арван найман сая долоон зуун хорин мянга) төгрөгөөр “Оргил цамхаг констракшн” ХХК-тай шууд гэрээ байгуулах эрхийг аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Давааням)-т олгосугай.

2. Гэрээнд заагдсан ажлуудыг холбогдох хууль, журам, норм дүрмийн дагуу тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Оргил цамхаг констракшн” ХХК (Л.Цэнд-Аюуш)-д үүрэг болгосугай.


3. Дээрх зураг төсөл боловсруулах ажилд чанарын болон хугацааны хяналт тавьж хүлээн авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн бөгөөд Аймгийн Ерөнхий архитектор (М.Цэрэнчимэд)-д даалгасугай.

4. Дээрх ажлуудын санхүүжилтийг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн II дугаар хавсралтын хуулийн дугаар XII.1.111 дэх хэсгийн батлагдсан төсвөөс гэрээнд заагдсан үнийн дүнгээр санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Sugar Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324010091